

06. Багшийн журнал-Үнэлгээ-1 /Бүлэг сэдвийн үнэлгээ/

Үнэлгээ-1 буюу суралцагчдыг бүлэг сэдвээр үнэлэх

Зорилго:

Суралцагч тухайн бүлэг сэдвийг ойлгосон түвшнийг тодорхойлох, сэдвийн хүрээнд мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүнг үнэлж, дүгнэх, чанарын үнэлгээ хийх

Бүлэг сэдвийн үнэлгээ оруулахад дараах зүйлүүдийг урьдчилан хийсэн байх шаардлагатай:

- Сэдвийн сан үүсгэх
- Бүлэг сэдвийг шинээр бүртгэх
- Бүлэг сэдэв бүр дээр **Суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг үнэлэх шалгуур** оруулна. Энэ хүү шалгуураар Үнэлгээ-1 буюу бүлэг сэдвийн үнэлгээ хийгдэнэ.

Бүлэг сэдвийн үнэлгээ оруулах дараалал

- Багшийн журнал -> Үнэлгээ 1
- Үнэлгээ хийх хичээл, улирлаа сонгоно.
- Үнэлгээний үзүүлэлт
- Огноо болон бүлэг сэдвийн нэр сонгох
- Үнэлгээний дүгнэлт, тайлбар оруулах (Сурагч нэг бүрийн үнэлгээг оруулсны дараа энэ хүү хэсэгт үнэлгээний тухай нэгдсэн дүгнэлт оруулна.)
- Хадгалах ба үнэлэх

Багшийн журнал үйл ажиллагаа дотор Үнэлгээ – 1 хуудаст орж Үнэлгээ нэмэх дарахад дээрх цонх гарч ирнэ.

Анхаарах:

1. Бүлэг сэдвийн дүгнэлт хэсэгт анги нийтээр тухайн бүлэг сэдвийн хүрээнд суралцагчдын ойлгоцын түвшинг хувиалан нэгдсэн дүгнэлтийг бичнэ.
2. Дүн оруулах цонхонд үнэлгээг оруулна. Үнэлгээ хэсэгт I-VIII түвшин бодогдож харуулна.
3. Тайлбар хэсэгт суралцагч ямар учраас ийм дүн авсан бэ? гэдгийг бичиж болно. Энэ нь эцэг эхийн системээр дамжин суралцагчийн эцэг эхэд харагддаг байна.
4. Бүх бүртгэлийг хийж дуусгасан бол Хадгалах товч дарна.